



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар A/50

Улаанбаатар хот

Ажлын цагийн горимд өөрчлөлт
оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, 10 дугаар зүйлийн 10.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3, 84 дүгээр зүйлийн 84.1, 84.2 дахь хэсэг, Хүүхдийн төлөө Үндэсний зөвлөлийн 2018 оны "Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай" 03 дугаар тогтоолын 7.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх, нийслэлийн авто замын ачааллыг харгалзан байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлөөс ирүүлсэн саналын дагуу төв байгууллагын ажил эхлэх, тараах цагийн горимыг дор дурдсанаар өөрчилсүгэй.

Эхлэх цаг 08:15, үдийн завсарлага 12:00-13:00, дуусах цаг 16:00.

2. Ажлын цагийн горим өөрчилсөнтэй холбогдуулан Виз, зөвшөөрлийн газар, Зөрчил шалган шийдвэрлэх газар өглөө 08:00, орой 16.30 цаг хүртэл чиг үүргийн дагуу иргэдэд үйлчлэх зорилгоор дотоод зохион байгуулалт хийхийг харьяалах нэгжийн дарга (Д.Алтанзул, Х.Бэхбат) нарт үүрэг болгосугай.

3. Албан хаагчдын ажил үүргийн онцлогийг харгалзан Долоо хоногт 1 удаа цахимаар, зайнаас (хуваарийн дагуу) ажиллуулж болохыг төв байгууллагын газар, хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал баталсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2022 оны А/66 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 5.2 дахь хэсэгт "төв зохион байгуулалтын нэгжид ажлын цаг 08:00 цагт эхэлж, 16:30 цагт дуусна" гэснийг "08:15 цагт эхэлж, 16:00 цагт дуусна" гэж өөрчилсүгэй.

5. Ажлын цагийн горим өөрчилсөнтэй холбогдуулан албан хаагчдын цалин, хөлсний хэмжээ өөрчлөгдөхгүйг Санхүүгийн хэлтэс (Ж.Солонго)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Д.Давааням)-т тус тус даалгасугай.

6. Энэ тушаалыг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Н.УУГАНБАЯР

172301335